



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 08 сарын 31 өдөр

Дугаар А/620

Булган сум

Албан томилолтоор ажиллахад хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.9 дэх заалт, Сангийн сайдын “Гадаад албан томилолтын зардлын хэмжээ шинэчлэн батлах тухай” 2011 оны 188 дугаар тушаал, аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны “Шинэ хөгжлийн зам” хөтөлбөрийг батлах тухай аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны II/04 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын А/593 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Булган аймгийн төлөөлөгчид 2023 оны 09 дүгээр сарын 07-16-ны өдрүүдэд Бүгд Найрамдах Солонгос Улсад албан томилолтоор ажиллахад шаардагдах зардлыг хавсралтаар баталсугай.

2.Хавсралтад тусгагдсан 17,477,400 (арван долоон сая дөрвөн зуун далан долоон мянга дөрвөн зуу) төгрөгийг “Шинэ ирээдүй” хөтөлбөр, төлөвлөгөө хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газар (Д.Алтаншагай)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Б.АРИУН-ЭРДЭНЭ

Аймгийн Засаг даргын 2023 оны
08 дугаар сарын 31-ны өдрийн Д.620 дугаар
захирамжийн хавсралт



ГАДААД АРГА ХЭМЖЭЭНД ШААРДАГДАХ
ЗАРДЛЫН ТООЦОО

№	Зардлын нэр	Мөнгөн дүн /төгрөг/
2	Тийз	1,890,000*3=5,670,000
3	Томилолт	200*3473*3 хоног=2,083,800 200*3473*14 хоног=9,724,400
	Нийт дүн	17,477,400